

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын Стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/636
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үндсэн хөрөнгийн ангилалд шинжилгээ хийж, үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт стандартыг мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Цэгцтөв Богд Аудит ХХК-ийн аудитор Г.Цэцэгмаа, туслах аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Цэгцтөв Богд Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Одон орон, геофизикийн хүрээлэн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх, судалгаа боловсруулалтын ажил эрхлэх, төсөл хэрэгжүүлэх, инновацийг бий болгож үр дүнг нэвтрүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Одон орон, геофизикийн хүрээлэн дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Газар хөдлөл судлал
- Соронзон судлал
- Нарны физик судлал
- Астрометри судлал
- Астропарк

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Одон орон, геофизикийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous", цалин хөлсний "Payroll" програм хангамж ашигладаг байна.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Одон орон, геофизикийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,149,861.2 мянган төгрөгөөс тооцон 42,997.2 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 79,094.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 478,627.6 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		15.8	15.8
Бараа материал	64,749.2	38,086.1	(26,663.1)
Үндсэн хөрөнгө	8,970,751.7	9,017,645.7	46,894.0
Хуримтлагдсан элэгдэл	3,305,036.0	3,803,910.3	(498,874.3)
Нийт хөрөнгө	5,730,464.9	5,251,837.3	(478,627.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,730,464.9	5,251,837.3	(478,627.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,730,464.9	5,251,837.3	(478,627.6)

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь Монгол Улсын хэмжээнд газар хөдлөлтийн аюулаас амжиж анхааруулах, газар хөдлөлийн мэдээллийг 24 цагийн турш тасралтгүй бүртгэх мэдээллийг төвд дамжуулах, 140 станцуудын хэвийн үйл ажиллагааг хангах шаардлагатай тусгай зориулалтын материал, түлш шатах тослох материал, хэрэгслийг өмнөх онд бэлтгэсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46,894.0 мянган төгрөгөөр өссөн нь хүрээлэнгийн төвийн бүртгэлд 6 нэр төрөл, орон нутгийн салбарт 11 нэр төрөл нийт 43,833.8 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд 1 нэр төрлийн 7,894.1 мянган төгрөгийн зөөврийн плантариум, Алтай станцын конторын барилгад 7,848.0 мянган төгрөгийн сайжруулалт хийж мөн ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А-4/1614, 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А-2/2258 тоот тушаалын дагуу хөрөнгө худалдан авч бүртгэлд тусгасантай холбоотой.

Хүрээлэнгийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дүгнэлт шийдвэр болон ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А-1/4396 тоот тушаалын дагуу 12,681.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн тайлант онд 116,940.0 мянган төгрөгийн өөрийн орлогын төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 115,830.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99,9 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 1,109.5 мянган төгрөгөөр тасарсан нь шинээр баригдах барилгын газар хөдлөлийн балл хэмжих захиалгат ажлын тоо хэмжээ багассантай холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,220,117.6 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр 3,219,008.1 мянган

төгрөгийн орлого бүрдүүлж 3,218,928.9 мянган төгрөгийг зарцуулж 79.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт гүйцэтгэл 3,218,928.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 72,945.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 95,788.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 87,198.3 мянга, нийт 255,931.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 38,187.2, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,998.9, хангамж бараа материалын зардалд 12,359.2, эд хогшил урсгал засварын зардалд 30656.8, дотоод албан томилолтын зардалд 78,250.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 8,690.4, хичээл үйлдвэрлэлийн зардалд 204.0, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардалд 85,585.2, нийт 255,931.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 181.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 34 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,133.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Албан томилолтоор ажилласан хугацаанд ажиллагчдад унаа, хоолны нэмэгдэл 103.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан томилолтоор ажиллах хугацаанд унаа, хоолны нэмэгдэл давхардуулан олгосныг төлүүлэн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

2. Ажиллагсдад үндсэн цалин, амралтын цалинтай давхардуулан 277.5 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3-т “ажил олгогч нь бүх ажилтанг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ”, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т “ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажилчдад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан олгосныг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3. Төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, 6,751.9 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл хөлс олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т зааснаар "төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл төрийн албанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болох бөгөөд цалин хөлс нь зөвхөн

хөдөлмөрийн гэрээнд зааснаар тодорхойлогдоно” Энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4-т зааснаар “тэтгэвэрт гарахынхаа өмнө нь авч байсан цалин хөлсийг сэргээж олгох эрх зүйн үндэслэлгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, цалингийн нэмэгдэл хөлс олгосныг төлүүлэн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй болон анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Одон орон, геофизикийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 16 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,997.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна

Нийт 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 57 нэр төрлийн шинж чанарын хувьд ижил хөрөнгүүдийн ашиглах жил харилцан адилгүй тогтоосон, элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон 60 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэх талаар шийдвэрлээгүй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолын хавсралт Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д зааснаар "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

УСНББОУС-17, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлэх, шинж чанарын хувьд ижил төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүсэлт гаргаж дахин үнэлэх асуудлыг шийдвэрлүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>64,749,235.13</u>	<u>38,101,895.25</u>
33	АВЛАГА		15,779.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		15,779.52
35	БАРАА МАТЕРИАЛ	64,749,235.13	38,086,115.73
351	Түүхий эд материал	46,486,204.13	36,591,204.13
35110	Тусгай зориулалттай материал	46,486,204.13	36,591,204.13
354	Хангамжийн материал	18,263,031.00	1,494,911.60
35410	Бичиг хэргийн материал	7,831,981.00	441,541.60
35420	Аж ахуйн материал	577,750.00	1,053,370.00
35430	Сэлбэг хэрэгсэл	427,300.00	-
35440	Түлш, шатах тослох материал	9,426,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,665,715,728.05</u>	<u>5,213,735,422.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,665,715,728.05	5,213,735,422.75
392	Биет хөрөнгө	4,517,207,206.73	4,112,842,241.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,448,648,709.94	3,456,496,709.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	104,293,789.57	214,330,942.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	196,142,987.28	196,142,987.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	106,887,153.99	116,897,154.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,751,298,989.65	3,788,094,169.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	2,717,237,199.66	3,042,848,000.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,408,242.79	121,349,037.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	70,641,144.92	78,932,130.73
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,300,000.00	1,300,000.00
39217	Ном	2,467,565.21	2,467,565.21
393	Биет бус хөрөнгө	1,148,508,521.32	1,100,893,181.70
39301	Програм хангамж	657,705,637.00	655,565,637.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	288,024,215.80	333,362,055.30
39303	Бусад биет бус хөрөнгө	796,779,600.00	796,229,600.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	17,952,499.88	17,540,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,730,464,963.18</u>	<u>5,251,837,318.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,730,464,963.18</u>	<u>5,251,837,318.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,730,464,963.18	5,251,837,318.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,889,184,696.66	2,889,184,696.66
51101	Өмч: - төрийн	2,889,184,696.66	2,889,184,696.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,844,990,977.87	1,366,363,332.69
51210	Өмнөх үеийн үр дүн	3,218,609,734.48	1,844,990,977.87
51220	Тайлант үеийн үр дүн	(1,373,618,756.61)	(478,627,645.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	996,289,288.65	996,289,288.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,730,464,963.18</u>	<u>5,251,837,318.00</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,340,894,235.38	3,476,121,538.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,672,493.14	116,830,548.35
120	Нийтлэг татварын бус орлого	197,672,493.14	116,830,548.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	197,672,493.14	116,830,548.35
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,028,000.00	58,890,548.35
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,891,769.28	56,940,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,752,723.86	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,143,221,742.24	3,359,290,990.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,466,197,400.00	3,103,177,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,466,197,400.00	3,103,177,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	675,931,219.08	256,113,390.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	72,944,990.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	674,431,219.08	85,763,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	97,404,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,093,123.16	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,093,123.16	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,297,044,019.73	3,954,749,183.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,297,044,019.73	3,954,749,183.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,284,285,496.37	3,944,489,584.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,714,069,097.46	1,895,693,291.68
210101	Үндсэн цалин	1,560,153,460.67	1,696,791,662.77
210102	Нэмэгдэл	9,023,535.00	144,032,920.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт		20,911,100.00
210104	Урамшуулал	10,089,347.99	2,527,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	134,802,753.80	31,430,208.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,675,593.97	238,908,328.02
210201	Тэтгэврийн даатгал	138,814,770.37	167,233,721.73
210202	Тэтгэмжийн даатгал	17,215,205.90	17,924,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,772,164.72	14,316,306.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,443,041.18	3,584,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,430,411.80	35,848,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,566,745.47	224,533,710.18
210301	Гэрэл, цахилгаан	132,892,680.00	154,767,312.74

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	59,992,513.58	56,498,828.55
210303	Цэвэр, бохир ус	9,681,551.89	13,267,568.89
2104	Хангамж, бараа материалын зардал	131,923,338.96	77,162,217.40
210401	Бичиг хэрэг	62,985,599.00	16,199,989.00
210402	Тээвэр, шатахуун	3,569,800.00	5,274,666.59
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,948,574.99	38,481,261.81
210404	Ном, хэвлэл	11,373,200.00	7,684,025.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,005,632.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,046,164.97	8,516,643.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	290,095,789.89	88,463,183.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	270,863,389.89	47,061,183.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,653,800.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	13,578,600.00	38,402,000.00
2107	Томилолт, зочны зардал	111,296,899.00	138,250,009.72
210702	Дотоод албан томилолт	111,296,899.00	138,250,009.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,042,223,548.60	753,779,921.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,035,947,009.60	747,066,509.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,000.00	722,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	591,500.00	435,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	55,000.00
210807	Газрын төлбөр	1,987,539.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	584,434,483.02	527,698,922.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	16,142,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	584,434,483.02	511,556,222.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,758,523.36	10,259,599.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	9,998,810.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,998,810.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,758,523.36	260,789.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,758,523.36	79,168.69
	Нэмэлт санхүүжилттөвлөрүүлэх шилжүүлэг	-	181,620.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(956,149,784.35)	(478,627,645.18)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	417,468,972.26	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	417,468,972.26	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(417,468,972.26)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,373,618,756.61)	(478,627,645.18)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,453,815,386.36</u>	<u>3,475,121,538.51</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,919,769.28	115,830,548.35
120	Нийтлэг татварын бус орлого	128,919,769.28	115,830,548.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,919,769.28	115,830,548.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,028,000.00	58,890,548.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,891,769.28	56,940,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,324,895,617.08	3,359,290,990.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,466,197,400.00	3,103,177,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,466,197,400.00	3,103,177,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	858,698,217.08	256,113,390.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	72,944,990.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	857,198,217.08	85,763,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	97,404,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,355,674,716.28</u>	<u>3,415,545,621.51</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,355,674,716.28	3,415,545,621.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,342,916,192.92	3,405,286,022.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,714,091,521.05	1,895,693,291.68
210101	Үндсэн цалин	1,560,175,884.26	1,696,791,662.77
210102	Нэмэгдэл	9,023,535.00	144,032,920.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт		20,911,100.00
210104	Урамшуулал	10,089,347.99	2,527,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	134,802,753.80	31,430,208.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,582,470.81	238,924,107.54
210201	Тэтгэврийн даатгал	137,721,647.21	167,249,501.25
210202	Тэтгэмжийн даатгал	17,215,205.90	17,924,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,772,164.72	14,316,306.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,443,041.18	3,584,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,430,411.80	35,848,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,536,030.47	215,107,710.18
210301	Гэрэл, цахилгаан	132,892,680.00	154,767,312.74
210302	Түлш, халаалт	56,961,798.58	47,072,828.55
210303	Цэвэр, бохир ус	9,681,551.89	13,267,568.89
2104	Хангамж, бараа материалын зардал	63,312,282.99	68,746,998.00
210401	Бичиг хэрэг	23,186,440.00	8,309,149.60

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	3,569,800.00	4,274,666.59
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,992,464.99	38,481,261.81
210404	Ном, хэвлэл	14,339,600.00	7,684,025.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,005,632.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,223,978.00	8,992,263.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,311,280.00	78,140,883.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,462,680.00	36,738,883.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,296,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	13,552,600.00	38,402,000.00
2107	Томилолт, зочны зардал	111,296,899.00	138,250,009.72
210702	Дотоод албан томилолт	111,296,899.00	138,250,009.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,019,785,708.60	754,280,321.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,013,509,169.60	747,566,909.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,000.00	722,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	591,500.00	435,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	55,000.00
210807	Газрын төлбөр	1,987,539.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,142,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	16,142,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,758,523.36	10,259,599.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	9,998,810.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,998,810.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,758,523.36	260,789.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,758,523.36	79,168.69
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	181,620.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>98,140,670.08</u>	<u>59,575,917.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	98,140,670.08	59,575,917.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,140,670.08	59,575,917.00
2200	Дотоод эх үүсвэрээр	98,140,670.08	59,575,917.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	98,140,670.08	59,575,917.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(98,140,670.08)</u>	<u>(59,575,917.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,110,495,096.66	0.00	3,218,609,734.48	5,329,104,831.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,110,495,096.66	0.00	3,218,609,734.48	5,329,104,831.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		996,289,288.65		996,289,288.65
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	778,689,600.00			778,689,600.00
C07	Тайлант үеийн үр дүн			-1,373,618,756.61	-1,373,618,756.61
C08	2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	1,844,990,977.87	5,730,464,963.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	1,844,990,977.87	5,730,464,963.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-478,627,645.18	-478,627,645.18
D09	2019 оны 12-р дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	1,366,363,332.69	5,251,837,318.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,220,117,600.00	3,218,928,979.66	1,188,620.34	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,220,117,600.00	3,218,928,979.66	1,188,620.34	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,210,117,600.00	3,208,930,169.66	1,187,430.34	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,862,295,300.00	1,861,735,683.68	559,616.32	99.9
210101	Үндсэн цалин	1,694,808,800.00	1,696,791,662.77	(1,982,862.77)	100.1
210102	Нэмэгдэл	144,115,900.00	144,032,920.91	82,979.09	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,370,600.00	20,911,100.00	2,459,500.00	89.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234,717,800.00	234,694,506.29	23,293.71	99.9
210201	Тэтгэврийн даатгал	163,019,900.00	163,019,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,924,500.00	17,924,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,339,600.00	14,316,306.29	23,293.71	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,584,900.00	3,584,900.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	35,848,900.00	35,848,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,108,800.00	213,108,799.75	0.25	100.0
210301	Гэрэл, цахилгаан	132,385,100.00	153,818,812.74	(21,433,712.74)	116.2
210302	Түлш, халаалт	71,338,500.00	46,022,418.12	25,316,081.88	64.5
210303	Цэвэр, бохир ус	9,385,200.00	13,267,568.89	(3,882,368.89)	141.4
2104	Хангамж, бараа материалын зардал	56,387,800.00	56,387,800.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	3,373,900.00	5,728,906.00	(2,355,006.00)	169.8
210402	Тээвэр, шатахуун	11,532,800.00	4,274,666.59	7,258,133.41	37.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,400,000.00	35,306,955.41	(8,906,955.41)	133.7
210404	Ном, хэвлэл	6,517,100.00	3,646,800.00	2,870,300.00	55.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,005,632.00	994,368.00	50.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,564,000.00	6,424,840.00	139,160.00	97.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,900,000.00	93,900,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,900,000.00	45,900,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	45,000,000.00	45,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	60,000,000.00	60,000,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	60,000,000.00	60,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	673,769,200.00	673,164,679.94	604,520.06	99.9

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	666,756,100.00	666,451,267.94	304,832.06	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00		100.0
210803	Даатгалын үйлчилгээ	722,500.00	722,500.00		100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	647,600.00	435,912.00	211,688.00	67.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	55,000.00	88,000.00	38.5
210807	Газрын төлбөр	2,000,000.00	2,000,000.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,938,700.00	15,938,700.00		100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,938,700.00	15,938,700.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00	9,998,810.00	1,190.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	9,998,810.00	1,190.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	9,998,810.00	1,190.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,220,117,600.00	3,218,928,979.66	1,188,620.34	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,103,177,600.00	3,103,098,431.31	79,168.69	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,103,177,600.00	3,103,098,431.31	79,168.69	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	116,940,000.00	115,830,548.35	1,109,451.65	99.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000,000.00	58,890,548.35	1,109,451.65	98.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,940,000.00	56,940,000.00	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		256,113,390.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		256,113,390.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		255,931,769.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		33,957,608.00
210104	Урамшуулал		2,527,400.00
210105	Гэрээт ажлын хөлс		31,430,208.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,229,601.25
210201	Тэтгэврийн даатгал		4,229,601.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,998,910.43
210301	Гэрэл, цахилгаан		948,500.00
210302	Түлш, халаалт		1,050,410.43
2104	Хангамж, бараа материалын зардал		12,359,198.00
210401	Бичиг хэрэг		2,580,243.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,174,306.40
210404	Ном, хэвлэл		4,037,225.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,567,423.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		30,656,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		29,406,800.00
210604	Урсгал засвар		1,250,000.00
2107	Томилолт, зочны зардал		78,250,009.72
210702	Дотоод албан томилолт		78,250,009.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		94,275,642.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		94,275,642.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		204,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		204,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		181,620.73
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт		181,620.73
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		181,620.73
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		256,113,390.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		72,944,990.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		85,763,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		97,404,700.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аудитын код:
2020.02.18	2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Одон орон, геофизикийн хүрээлэн	САГ-2020/168/СТА- ТШЗ

/мянган төгрөг/

№	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 57 нэр төрлийн шинж чанарын хувьд ижил хөрөнгүүдийн ашиглах жил харилцан адилгүй тогтоосон, элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон 60 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэх талаар шийдвэрлээгүй байна	-	Зөвлөмж өгсөн	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	С. Дэмбэрэл М.Мөнгөнцэцэг
2	Албан томилолттой хугацаанд ажиллагчдад унаа, хоолны нэмэгдлийг давхардуулан олгосон	103.6	Төлбөрийн акт тогтоосон	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	С. Дэмбэрэл М.Мөнгөнцэцэг
3	Ажиллагсдад үндсэн цалин, амралтын цалинтай давхардуулан олгосон	277.5	Төлбөрийн акт тогтоосон	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	С. Дэмбэрэл М.Мөнгөнцэцэг
4	Төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, цалин, нэмэгдэл хөлс олгосон	6,751.9	Төлбөрийн акт тогтоосон	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	С. Дэмбэрэл М.Мөнгөнцэцэг
	ДҮН	7,133.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 03 № 02/43
СЯГ-2020/168/СТА-ТМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Албан томилолттой хугацаанд ажиллагчдад унаа, хоолны нэмэгдэл 103.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.
2. Ажиллагсдад үндсэн цалин, амралтын цалинтай давхардуулан 277.5 мянган төгрөгийг олгосон
Энэ нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3-т “ажил олгогч нь бүх ажилтанг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ”, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т “ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
3. Төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, 6,751.9 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл хөлс олгосон.
Энэ нь: Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т зааснаар төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл төрийн албанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болох бөгөөд цалин хөлс нь зөвхөн хөдөлмөрийн гэрээнд зааснаар тодорхойлогдоно” Энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4-т зааснаар “тэтгэвэрт гарахынхаа өмнө нь авч байсан цалин хөлсийг сэргээж олгох эрх зүйн үндэслэлгүй” заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төрсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.




\\10.10.10.20\Bichig_Khereg\Aкт\2020\0303SAG2.Docx

001090063

Албан томилолттой хугацаанд унаа, хоолны нэмэгдэл давхардуулан олгосон 103.6 мянга, ажилчдад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан олгосон 277.5 мянга, төрийн албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, цалингийн нэмэгдэл хөлс олгосон 6,751.9 мянга, нийт 7,133.0 мянган төгрөгийг гаргуулж Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор төвлөрүүлэх.

1. Биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл, ерөнхий нягтлан бодогч М.Мөнгөнцэцэг нарт даалгав.

АКТЫГ:

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
 Д.ЦЭРЭНДОРЖ
“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ”ХХК
АУДИТОР  Г.ЦЭЦЭГМАА

ЗӨВШӨӨРСӨН:
ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
 С.ДЭМБЭРЭЛ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
М.МӨНГӨНЦЭЦЭГ
ТТГ 524 9095349

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.